



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/323

Хэрлэн сум

Хэрлэн-Өндөрхаан харуулын  
усны хэмжилтийн ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6, аймгийн онцгой комиссын 2024 оны 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хэмжээнд үер, усны аюул, гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэрлэн-Өндөрхаан харуулын усны хэмжилтийн ажилд шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Хэрлэн-Өндөрхаан харуулын усны хэмжилтийн ажлыг өдөр тутамд хийж ард иргэдэд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг тухай бүр хүргэж ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-т үүрэг болгосугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ